



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/266

Мандалговь

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 дэхь заалт, Засаг даргын зөвлөлийн хурлын 2021 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчний эрсдэлтэй бүс нутгаас ирж буй малын шилжилт хөдөлгөөнийг тандах, отор нүүдэл хийж байгаа малчидтай уулзах, малд эрүүл мэндийн үзлэг хийх ажлын шатахууны зардалд зарцуулах 467,100 (дөрвөн зуун жаран долоон мянга нэг зуун) төгрөгийг зарцуулсугай.

2. Шатахууны зардалд шаардагдах 467,100 (дөрвөн зуун жаран долоон мянга нэг зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор)-т зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

481210014